

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2021 оны 06 дугаар сарын 30-
ний өдрийн 4118/2021 албан
бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Г.ДАМДИННЯМЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД Л.ХАЛТАРТ
2021 ОНЫ 06 ДУГААР САРЫН 17-НИЙ ӨДРИЙН 24 ДУГААРТАЙ
АЛБАН БИЧГЭЭР ТАВЬСАН АСУУЛТЫН ХАРИУ

1. Улаанбаатар-Дархан чиглэлийн замын Багц 1-2 болон Багц 1-4 ажлын гүйцэтгэгч байгууллагаар шалгарсан "Чайна Стэйт Шинжиан Констракшн Инженеринг групп"-ийг сонгон шалгаруулсан, гэрээ байгуулсан үйл явц болон 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан гэрээнд хийсэн эрх зүйн дүгнэлт, мөн хууль хяналтын байгууллагаар шалгаруулсан бол энэ талаарх мэдээлэл, шалгуулаагүй бол яагаад энэ талаар ажиллаагүй байгаа талаар:

АХБ-ны МОН-3679 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл"-ийн Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 5 багц хэсэг бүхий олон улсын тендерийг АХБ-ны "Худалдан авах ажиллагааны журам"-ын дагуу 2019 оны 3-5 дугаар саруудад зохион байгуулсан ба шалгарсан гүйцэтгэгч байгууллагуудтай 2021 оны 06 сарын 12-14-ны өдрүүдэд гэрээ байгуулсан.

Төслийн Багц 1-2 хэсэг буюу Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км авто замыг барих 160 дугаартай, Багц 1-4 хэсэг буюу Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэлх 45.08 км авто замыг барих 161 дугаартай гэрээг тус тус 2019 оны 06 дугаар сарын 19-ны өдөр БНХАУ-ын Чайна Стэйт Шинжиан Констракшн Инженеринг групп компанитай байгуулсан.

Гүйцэтгэгч компанийн байрладаг БНХАУ-ын Шинжиан мужид Ковид-19 цар тахлын нөхцөл байдалд тогтоосон хорио цээрийн улмаас гадаад ажиллах хүч Монгол Улсад орж ирж чадахгүй болсонд үндэслэн гүйцэтгэгч байгууллагаас 2020 оны 08 сарын 06-ны өдөр гэрээ цуцлах хүсэлт ирүүлсэн ба Гэрээний ерөнхий нөхцөл /цаашид ГЕН гэх/-ийн 19.6 дугаар заалтыг үндэслэн гэрээт ажлыг 2020 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөр дуусгавар болгож цуцалсан.

Гэрээ цуцлахтай холбогдох эцсийн тооцоо, тайланг боловсруулах үйл ажиллагааг ажил гэрээний ГЕН-ийн 19.6-д заасны дагуу хэрэгжүүлж байна. Гүйцэтгэгч байгууллагаас төслийн зөвлөх багийн боловсруулсан эцсийн тооцоо, тайланд санал нэгдэхгүй асуудал гарсан ба талбайн хэмжилтийг гүйцэтгэгч, зөвлөхийн төлөөлөл дахин хамтарч хийж, хэмжилтийн үр дүнг дахин боловсруулах зэргээр хугацаа алдах асуудал гарсан.

Зам барилгын ажлын гэрээ нь АХБ-ны хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилгын ажилд мөрдөгддөг гэрээний жишиг болох Олон улсын инженерүүдийн нийгэмлэгээс боловсруулагдсан олон улсын жишиг гэрээний 2010 оны хувилбарт үндэслэгдсэн болно.

Тус олон улсын гэрээнд гэрээтэй холбогдох аливаа маргаан нь гэрээний талуудын хараат бус байдлыг хангах хүрээнд гуравдагч этгээдээр шийдвэрлэгдэхээр заасан байдаг ба Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын барилгын ажлын гэрээнд гэрээтэй холбогдох аливаа маргаан нь Гэрээний тусгай нөхцөлийн 20.6.а-д заасны

дагуу Сингапурын олон улсын арбитрын төвөөр шийдвэрлэгдэхээр, мөн маргаан шийдвэрлэх үйл ажиллагаа нь тус арбитрын төвийн хууль, дүрмээр явагдахаар заасан.

Ийнхүү гэрээний дагуу гэрээний төлбөр тооцоог эцэслэн шийдвэрлэх асуудлыг удаашруулж байгаа үндэслэлээр гүйцэтгэгч байгууллагыг дотоодын хууль хяналтын байгууллагад хандах боломжгүй ба Сингапурын арбитрт хандах тохиолдолд ихээхэн хугацаа алдах эрсдэлтэй байгаа болно.

2. Тус замын АХБ-ны зээлийн санхүүжилттэй урсгалын Багц 1-2, Багц 1-4 дугаар ажлын гацаанаас гаргаж эхлүүлэх, барьж дуусгахаар ямар ажил төлөвлөн хэрэгжүүлж байгаа талаар:

Багц 1-2 болон Багц 1-4 хэсгийн ажлыг хугацаа алдалгүй хэрэгжүүлэх хүрээнд дараагийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах олон улсын тендерийг АХБ-тай хэлэлцэж, зөвшилцсөний үндсэн дээр зөвшөөрлийг авч 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр зарласан ба тендерийг 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр нээсэн.

Үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэн эцсийн тайланг АХБ-нд 2021 оны 05 дугаар сарын 09-ны өдөр хүргүүлсэн. АХБ-аас тайланд зөвшөөрөл хүлээгдэж байна. АХБ нь холбогдох журмын дагуу өмнөх гүйцэтгэгч байгууллагатай эцсийн төлбөр тооцоог барагдуулсны дараагаар зөвшөөрөл олгохыг мэдэгдсэн болно.

Гэрээ цуцалсан гүйцэтгэгч байгууллагатай эцсийн төлбөр тооцоог ямарваа нэг маргаан гаргахгүйгээр шийдвэрлэх хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлыг дахин тодотгох зорилгоор гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн ажлын талбайн хэмжилтийг дахин зөвлөх, гүйцэтгэгчийн төлөөлөгчид хамтран 2021 оны 06 дугаар сарын 05-аас 11-ний өдрүүдэд гүйцэтгэсэн. Зөвлөх багаас хэмжилтийн үр дүнд үндэслэн эцсийн тооцоог боловсруулах ажлыг хэрэгжүүлж байна.

Зөвлөхөөс эцсийн төлбөр тооцооны тайланг захиалагч хүлээн авч, АХБ-нд холбогдох журмын дагуу хүргүүлэх ба АХБ-аас төлбөр тооцоог гүйцэтгэгчид олгогдсоноор төлбөр тооцооны асуудал дуусгавар болох ба мөн дараагийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний тайланд АХБ-аас зөвшөөрөл олгогдсоноор гэрээ байгуулах арга хэмжээг авна.

3. БНХАУ-ын "Чайна стэйт Шинжиан Констракшн инженеринг групп"-тэй байгуулсан гэрээг Монгол Улсад хохирол багатайгаар цуцлах, АХБ болон бусад оролцогч талуудтай зам барилгын ажлыг эхлүүлэх талаар хамтран хийж байгаа ажлууд түүнчлэн шинээр гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах ажлын явцын талаар;

"Чайна стэйт Шинжиан Констракшн инженеринг групп"-тэй байгуулсан гэрээ нь 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөр дуусгавар болсон ба одоогоор гэрээ цуцлагдсантай холбогдох эцсийн төлбөр, тооцоог дуусгавар болох үйл ажиллагааг гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа болно.

Гэрээнд заасны дагуу эцсийн төлбөр тооцооны тайланг Зөвлөх баг боловсруулж, захиалагчид ирүүлнэ.

Зам барилгын ажлын аль болох эрт хугацаанд эхлүүлэх хүрээнд АХБ-тай нягт хамтран ажиллаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүний дүнд дараагийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа ба өмнөх гүйцэтгэгчийн төлбөр, тооцоог дуусгавар болонгуут үнэлгээний тайланд зөвшөөрөл авч гэрээ байгуулах эрх нээгдэнэ.

4. Туслах, түр зам нь эвдрэл ихтэйгээс осол аваар ихээр гарч иргэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирч байгаа тухай гомдол, санал тасралтгүй ирсээр байгааг анхаарч засварын ажлын эвдрэл гарсан тухай бүрд нь хэрхэн гүйцэтгэж байгаа талаар болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар;

Багц 1-2 хэсэг болон Багц 1-4 хэсэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад анхаарч ажиллаж байна.

Зам барилгын ажлын гэрээ 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдөр цуцлагдсанаас хойших хугацаанд гүйцэтгэгч байгууллагын хийж байгаад орхигдсон ажлыг хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хэмжээнд засварласан. Мөн өвлийн улиралд хөдөлгөөнийг саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлж, замын арчлалтыг "Баянчандмань АЗЗА" ТӨХК, "Дархан АЗЗА" ТӨХК тус тус хариуцан ажилласан.

Тус хэсгүүдэд одоогоор авто замын үндсэн трассаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлж байна.

Багц 1-2 болон Багц 1-4 хэсгийн барилгын ажил эхлэх үеэр авто замын үндсэн трассыг хэсэгчлэн хаах /ажил хийгдэх хэсэгт/, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр замд шилжүүлэх арга хэмжээг авна. Түр замд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шилжүүлэхээс өмнө техникийн шаардлагад заасны дагуу түр замын засвар, арчлалтын ажлыг гүйцэтгүүлж, хөдөлгөөн саадгүй, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

5. Тус замтай холбоотой иргэдийн гомдол, саналыг гүйцэтгэгч компани тус бүрээс болон өөрийн яамны зүгээс хэрхэн шийдвэрлэж байгаа талаар:

Дээрх багц хэсгүүдийн барилгын ажилтай холбогдуулан туслан гүйцэтгэгчээр ажилласан иргэд, аж ахуйн нэгжүүдээс санхүүжилт, төлбөрийн асуудлаар хэд хэдэн өргөдөл, гомдлыг хүлээж авсан.

Гүйцэтгэгч байгууллагын дээрх 2 багц хэсгийн гүйцэтгэлийн баталгааг банкнаас гүйцэлдүүлж, яамны холбогдох дансанд байршуулсан байгаа ба туслан гүйцэтгэгчээр ажилласан иргэд, аж ахуйн нэгж болон орон нутгийн байгууллагуудын холбогдох төлбөрийг барагдуулсан баримт, материалыг үндэслэн гүйцэтгэлийн баталгааг буцаах нөхцөлийг гүйцэтгэгч байгууллагад тавьж байгаа болно.

Гүйцэтгэгч байгууллагаас туслан гүйцэтгэгчийн төлбөр тооцоог барагдуулсан талаарх зарим баримт, материалыг ирүүлж байна.